



- 6.6.2. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- 6.6.3. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
- 6.6.4. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 6.7. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 өдрийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.
- 6.8. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргана.
- 6.9. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг олгох бөгөөд энэ хугацаанд ногдол ашгийг төлөөгүй бол Компанийн тухай хуульд зааснаар алданги, хохирол төлөх хариуцлага хүлээнэ.
- 6.10. Компани ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал тайлагнана.
- 6.11. Ногдол ашиг хуваарилаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл үүний үндэслэл шалтгааныг хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулна.
- 6.12. Ногдол ашиг хуваарилах бодлого, түүнийг олгох, мэдээлэх журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал:

- 7.1.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 7.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
- 7.1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр зарлан хуралдуулна.
- 7.1.4. Энэ дүрмийн 7.1.3-д заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг зарлаагүй, эсхүл зарласан боловч хурлын бэлтгэлийг зохион байгуулаагүйн улмаас хурал хуралдаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дуусгавар болно.
- 7.1.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдах этгээдийг тухайн хурлыг зарласан этгээд хурал хуралдуулах тухай шийдвэрт заана.
- 7.1.6. Хурал хуралдуулах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл энэ дүрэмд заасан бусад этгээд гаргана.
- 7.1.7. Дараах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна. Үүнд:
 - а) Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 50-иас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон.



- б) Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан.
 - в) Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн.
 - г) Компанийн өр хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон.
 - д) Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан.
 - е) Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хийхийг шаардсан.
 - ж) Компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.
- 7.1.8. Энэ дүрмийн 7.1.7-ийн "б"-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд гаргах эрх эдэлнэ.
- 7.1.9. Төлөөлөн удирдах зөвлөл энэ дүрмийн 7.1.8-д заасан этгээдийн санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, эсэх талаар шийдвэр гаргана.
- 7.1.10. Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас татгалзсан шийдвэр гаргасан бол энэ тухайгаа энэ дүрмийн 7.1.8-д заасан санал, шаардлага гаргасан этгээдэд нэн даруй мэдэгдэнэ.
- 7.1.11. Энэ дүрмийн 7.1.9-д заасан хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргаагүй тохиолдолд энэ дүрмийн 7.1.8-д заасны дагуу санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч, эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.
- 7.1.12. Төлөөлөн удирдах зөвлөл энэ дүрмийн 7.1.9-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.
- 7.1.13. Дор дурдсан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:
- а) Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;
 - б) Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - в) Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - г) Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - д) Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
 - е) Хувьцааг хуваах, нэгтгэх;
 - ж) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
 - з) Хувьцаа, бусад хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх;





- и) Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- к) Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний хэлцлийг батлах;
- л) Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлэхээр оруулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- м) Компанийн өөрийн нийт гаргасан хувьцааны 5-аас илүү хувийг буцааж худалдаж авахыг зөвшөөрөх;
- н) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг шийдвэрлэх;
- о) Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

7.1.14. Энэхүү дүрмээр илүү өндөр хувь тогтоосноос бусад тохиолдолд дүрмийн 7.1.13.а)- 7.1.13.е)-д заасан асуудлыг тухайн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхийн саналаар, 7.1.13.ж)-7.1.13.о)-д заасан болон бусад асуудлыг тухайн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн энгийн олонхын саналаар тус тус шийдвэрлэнэ.

7.1.15. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох эрхтэй гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу явуулна.

7.1.16. Хувьцаа бүр саналын нэг эрхтэй байна. Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

7.1.17. Саналын эрхийн 30-аас дээш хувийг эзэмшигчид оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.

7.1.18. Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна.

7.1.19. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эрхийн хэмжээнд шийдвэрлэх асуудлыг санал зөрснөөс шийдвэрлэж чадахгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.

7.1.20. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.

7.2. Төлөөлөн удирдах зөвлөл:

7.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл байна.

7.2.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) Дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;
- б) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох, хурал хуралдуулах бусад асуудлыг шийдвэрлэх;
- в) Компанийн зарласан хувьцааны тоонд багтаан хувьцаа нэмж гаргах;
- г) Дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;



- д) Компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - е) Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - ж) Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
 - з) Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
 - и) Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах жийх гэрээний нөхцөлийг тогтоох;
 - к) Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
 - л) Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох;
 - м) Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - н) Компанийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах шийдвэр гаргах;
 - о) Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - п) Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоос бусад их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - р) Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - с) Компанийн эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах;
 - т) Компанийн тухай хууль болон хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.
- 7.2.3. Энэ дүрмийн 7.2.2 дахь заалтын "д", "и", "р" заалтад заасан асуудлыг шийдвэрлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд оролцож санал өгнө.
- 7.2.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэг жилийн хугацаатай сонгох бөгөөд тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дусгавар болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгож болно.
- 7.2.5. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан эсхүл нас барсан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль явуулах хүртэл Төлөөлөн удирдах зөвлөлөөс түр томилно.
- 7.2.6. Энэ дүрмийн 7.2.5-д заасны дагуу түр томилогдох этгээд нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрхийг эдэлнэ.
- 7.2.7. Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг, бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 7.2.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

